



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/115-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК  
Утас: 99396969 Цахим хаяг: [urtaa6969@gmail.com](mailto:urtaa6969@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b>	<b>4-5</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>6-11</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b>	<b>122</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	122
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	122
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	133
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	133
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b>	<b>166</b>
4.1 Ерөнхий зүйл	166
4.2 Материаллаг байдал	177
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	177
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	188
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	188
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	199
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>19-20</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>20-21</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН 2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ З.СЭЛЭНГЭ ТАНАА

2025.02.05 № 001-2025/15-НН-СГА-ШМЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 32,454.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7

удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>208,633,581.06</b>	<b>267,370,551.63</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>122,267,065.06</b>	<b>152,900,060.63</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>122,267,065.06</b>	<b>152,900,060.63</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>122,267,065.06</b>	<b>152,900,060.63</b>
31211	Төрийн сангийн харилцах	122,267,065.06	152,900,060.63
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>86,366,516.00</b>	<b>114,470,491.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>86,366,516.00</b>	<b>114,470,491.00</b>
35410	Бичиг хэргийн материал	39,500.00	39,500.00
35420	Аж ахуйн материал	78,755,257.00	105,894,842.00
3544	Түлш, шатах тослох материал	2,283,750.00	571,300.00
35460	Хүнсний материал	1,100,160.00	3,777,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,187,849.00	4,187,849.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,822,279,748.37</b>	<b>1,802,294,016.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,822,279,748.37</b>	<b>1,802,294,016.02</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,818,085,748.37</b>	<b>1,798,100,016.02</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,907,499,774.00	1,907,499,774.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(128,708,289.57)	(171,240,462.09)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	46,239,318.00	50,093,973.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,456,134.56)	(13,298,375.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,998,841.80	54,222,141.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,278,334.91)	(31,617,522.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,500,860.00	3,500,860.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(962,736.39)	(1,312,822.35)
39217	Ном	252,450.00	252,450.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,194,000.00</b>	<b>4,194,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	4,194,000.00	4,194,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,030,913,329.43</b>	<b>2,069,664,567.65</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,837,510.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,837,510.00</b>	<b>0.00</b>
413	Өглөг	2,587,510.00	0.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,587,510.00	0.00
4136	Бусад өглөг	250,000.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	250,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,028,075,819.43</b>	<b>2,069,664,567.65</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,028,075,819.43</b>	<b>2,069,664,567.65</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,194,000.00	4,194,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,023,881,819.43</b>	<b>2,065,470,567.65</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,023,881,819.43	2,023,881,819.43
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	41,588,748.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	0.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,030,913,329.43</b>	<b>2,069,664,567.65</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>824,792,890.52</b>	<b>1,167,663,247.03</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,475,470.00</b>	<b>62,606,933.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>32,475,470.00</b>	<b>62,606,933.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>305,000.00</b>	<b>35,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	31,801,648.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	32,170,470.00	30,770,285.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>792,317,420.52</b>	<b>1,105,056,314.03</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>750,537,000.00</b>	<b>1,049,820,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	750,537,000.00	1,049,820,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,000,000.00</b>	<b>930,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	930,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>40,780,420.52</b>	<b>54,306,114.03</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,780,420.52	54,306,114.03
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>733,770,864.56</b>	<b>1,126,074,498.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>733,770,864.56</b>	<b>1,126,074,498.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>717,392,664.56</b>	<b>1,104,978,898.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>449,918,176.00</b>	<b>748,339,785.00</b>
210101	Үндсэн цалин	334,595,720.00	493,981,901.00
210102	Нэмэгдэл	97,472,606.00	227,833,996.00
210104	Урамшуулал	17,849,850.00	26,523,888.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,545,399.02</b>	<b>96,457,394.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,014,832.84	65,572,382.44
210202	Тэтгэмжийн даатгал	4,825,274.36	7,610,980.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,662,333.84	4,474,315.37
210204	Ажилгүйдлийн даатгал	898,407.45	3,714,120.77
210205	Эрүүл мэндийн даатгал	9,144,550.53	15,085,595.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,159,670.52</b>	<b>38,003,864.03</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,806,420.52	10,301,864.03
210302	Түлш, халаалт	20,843,250.00	17,212,000.00
210303	Цэвэр, бохир ус	10,510,000.00	10,490,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>82,754,100.00</b>	<b>100,342,575.00</b>
210502	Хоол, хүнс	82,754,100.00	100,342,575.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,470,000.00</b>	<b>18,014,700.00</b>
210604	Урсгал засвар	3,470,000.00	18,014,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,259,900.00</b>	<b>2,810,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,259,900.00	2,810,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>80,285,419.02</b>	<b>101,010,580.35</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,033,091.00	25,786,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,139,600.00	15,575,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,112,728.02	59,648,680.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,378,200.00</b>	<b>21,095,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,378,200.00</b>	<b>21,095,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,378,200.00	21,095,600.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>91,022,025.96</b>	<b>41,588,748.22</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>91,022,025.96</b>	<b>41,588,748.22</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>792,622,420.52</b>	<b>1,105,091,314.03</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>305,000.00</b>	<b>35,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>305,000.00</b>	<b>35,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>305,000.00</b>	<b>35,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	35,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>792,317,420.52</b>	<b>1,105,056,314.03</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>750,537,000.00</b>	<b>1,049,820,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	750,537,000.00	1,049,820,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,000,000.00</b>	<b>930,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	930,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>40,780,420.52</b>	<b>54,306,114.03</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,780,420.52	54,306,114.03
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>673,881,245.54</b>	<b>1,066,597,018.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>673,881,245.54</b>	<b>1,066,597,018.46</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>657,503,045.54</b>	<b>1,045,501,418.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>449,668,176.00</b>	<b>748,589,785.00</b>
210101	Үндсэн цалин	334,345,714.00	494,231,901.00
210102	Нэмэгдэл	97,472,612.00	227,833,996.00
210104	Урамшуулал	17,849,850.00	26,523,888.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,545,399.02</b>	<b>96,457,394.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	41,014,832.84	65,572,382.44
210202	Тэтгэмжийн даатгал	4,825,274.36	7,610,980.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,662,333.84	4,474,315.37
210204	Ажилгүйдлийн даатгал	898,407.45	3,714,120.77
210205	Эрүүл мэндийн даатгал	9,144,550.53	15,085,595.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,310,420.52</b>	<b>36,291,414.03</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,806,420.52	10,301,864.03
210302	Түлш, халаалт	19,964,000.00	15,499,550.00
210303	Цэвэр, бохир ус	8,540,000.00	10,490,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>80,522,050.00</b>	<b>105,606,925.00</b>
210502	Хоол, хүнс	80,522,050.00	105,606,925.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,470,000.00</b>	<b>18,014,700.00</b>
210604	Урсгал засвар	3,470,000.00	18,014,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,259,900.00</b>	<b>2,810,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,259,900.00	2,810,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,727,100.00</b>	<b>37,731,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,947,500.00	29,293,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,779,600.00	8,438,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,378,200.00</b>	<b>21,095,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,378,200.00</b>	<b>21,095,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,378,200.00	21,095,600.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>118,741,174.98</b>	<b>38,494,295.57</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>7,516,700.00</b>	<b>7,861,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,516,700.00</b>	<b>7,861,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,516,700.00</b>	<b>7,861,300.00</b>
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(7,516,700.00)</b>	<b>(7,861,300.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>111,224,474.98</b>	<b>30,632,995.57</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		122,267,065.06
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		152,900,060.63

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,194,000.00	0.00	1,932,859,793.47	1,937,053,793.47
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	91,022,025.96	91,022,025.96
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,194,000.00	0.00	2,023,881,819.43	2,028,075,819.43
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	41,588,748.22	41,588,748.22
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,194,000.00	0.00	2,065,470,567.65	2,069,664,567.65

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,226,616,200.00	1,074,458,318.46	152,157,881.54	87.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,226,616,200.00	1,066,597,018.46	160,019,181.54	87.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,205,520,600.00	1,045,501,418.46	160,019,181.54	86.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	886,391,100.00	748,589,785.00	137,801,315.00	84.5
210101	Үндсэн цалин	606,103,200.00	494,231,901.00	111,871,299.00	81.5
210102	Нэмэгдэл	262,445,900.00	227,833,996.00	34,611,904.00	86.8
210104	Урамшуулал	17,842,000.00	26,523,888.00	(8,681,888.00)	148.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,705,200.00	96,457,394.43	7,247,805.57	93.0
210201	Тэтгэврийн даатгал	70,521,400.00	65,572,382.44	4,949,017.56	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,294,600.00	7,610,980.15	683,619.85	91.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,148,100.00	4,474,315.37	(326,215.37)	107.9
210204	Ажилгүйдлийн даатгал	4,148,100.00	3,714,120.77	433,979.23	89.5
210205	Эрүүл мэндийн даатгал	16,593,000.00	15,085,595.70	1,507,404.30	90.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,034,000.00	36,291,414.03	6,742,585.97	84.3
210301	Гэрэл, цахилгаан	14,022,000.00	10,301,864.03	3,720,135.97	73.5
210302	Түлш, халаалт	18,500,000.00	15,499,550.00	3,000,450.00	83.8
210303	Цэвэр, бохир ус	10,512,000.00	10,490,000.00	22,000.00	99.8
2105	Нормативт зардал	109,526,300.00	105,606,925.00	3,919,375.00	96.4
210502	Хоол, хүнс	109,526,300.00	105,606,925.00	3,919,375.00	96.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,530,000.00	18,014,700.00	(6,484,700.00)	156.2

210604	Урсгал засвар	11,530,000.00	18,014,700.00	(6,484,700.00)	156.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,897,200.00</b>	<b>2,810,000.00</b>	<b>87,200.00</b>	97.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,897,200.00	2,810,000.00	87,200.00	97.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>48,436,800.00</b>	<b>37,731,200.00</b>	<b>10,705,600.00</b>	77.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,998,600.00	29,293,000.00	10,705,600.00	73.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,438,200.00	8,438,200.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,095,600.00</b>	<b>21,095,600.00</b>	<b>0.00</b>	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,095,600.00</b>	<b>21,095,600.00</b>	<b>0.00</b>	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,095,600.00	21,095,600.00	0.00	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>7,861,300.00</b>	<b>(7,861,300.00)</b>	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	7,861,300.00	(7,861,300.00)	
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>1,105,056,314.03</b>	<b>(1,105,056,314.03)</b>	
<b>13</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>1,105,056,314.03</b>	<b>(1,105,056,314.03)</b>	
131001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	1,049,820,200.00	(1,049,820,200.00)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	930,000.00	(930,000.00)	
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	930,000.00	(930,000.00)	
132	Орон нутгийн төсөв	0.00	54,306,114.03	(54,306,114.03)	
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>35,000.00</b>	<b>(35,000.00)</b>	
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	35,000.00	(35,000.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		122,267,065.06	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		152,900,060.63	0.00	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь "Хүүхдийн эзэмших чадамж (танин мэдэхүйн, эрүүл мэнд, нийгэм-сэтгэл хөдлөл)-ийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж хичээл, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Тус байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд нас, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн зураг, дүрс, тэмдэг тэмдэглэгээний утга санааг ойлгох, бичвэр эхийг ойлгож унших, илэрхийлэх, тайлбарлах чадварыг өдөр тутам хичээл, үйл ажиллагаанд үр дүнтэй, бүтээлчээр хэрэгжүүлэх,
- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, 5 настай хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд хамруулах, сургуульд бэлтгэх, тэгш хамран сургалтыг хангаж ажиллах,
- Хүүхэд бүр сургалтын байгууллагын орчинд айдасгүй, амар тайван, эрүүл аюулгүй байдал орчныг бүрдүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлж хамтран ажиллах,
- Багшийн хөгжлийг дэмжих, уян хатан, олон хэлбэрт сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжин мэргэжлийн бүлгээр багаар ажиллах, сургалтын чанарт ахиц гаргах
- Багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг эрхэмлэн баг, хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*

- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өрчлөлтүүд**

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 38,751.2 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	122,267.10	152,900.00	30,632.90
Авлага	-		
Бараа материал	86,366.50	114,470.50	28,104.00
Үндсэн хөрөнгө	1,822,279.70	1,802,294.00	(19,985.70)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,030,913.30</b>	<b>2,069,664.50</b>	<b>38,751.20</b>
Өр төлбөр	2,837.50		(2,837.50)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,028,075.80	2,069,664.50	41,588.70
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,030,913.30</b>	<b>2,069,664.50</b>	<b>38,751.20</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 152,900.0 мянган төгрөг болж 30,632.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 114,470.5 мянган төгрөг болж 28,104.0 мянган төгрөгөөр өссөн нь сумын Орон нутгийг хөгжүүлэх сангаас 10,912.9 мянган төгрөгийн зөөлөн эдлэл, гал тогооны хэрэгсэл, эцэг эхчүүдээс 19,857.4 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, төсвийн хөрөнгөөр 165,745.8 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, 168,412.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,019,763.2 мянган төгрөг болж 11,077.9 мянган төгрөгөөр өссөн сумын Орон нутгийг хөгжүүлэх сангаас 7,080.6 мянган төгрөгийн хөрөгч, ус шүүгчийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор ашиглалтын хугацаа нь дууссан боловч цаашид дахин ашиглах боломжтой 24,721.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сунгасан, төсвийн хөрөнгөөр 7,861.3 мянган төгрөгийн сандал, ширээ бэлтгэж, сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолоор анхны өртгөө нөхсөн ашиглах боломжгүй 3,864.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, 59,648.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас,
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 2,837.5 мянган төгрөгөөр буурсан нь хүнсний материалын өглөгийг барагдуулснаас тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 911,107.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 67,029.5 мянган төгрөг нийт 978,136.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлсийг 162,480.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 27,660.3 мянган төгрөгөөр нийт 190,140.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 36,516.4 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг 824,512.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсөвт 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 360,454.8 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 33,396.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 19,376.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,599.0 мянган төгрөгөөр нийт 414,827.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлыг 12,723.4 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,049,785.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 54,564.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 122,267.1 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт **1,226,616.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,226,616.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,074,458.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,074,458.3 мянган төгрөг буюу 87.6 хувьтай байгаа нь хоолны зардал 3,118.1 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 149,039.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэл т
1	71801- Сургуулийн өмнөх боловсрол	1	80233- Хүүхэд хамгаалал	1,286.0	1,286.0	-	100.0
		2	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,200.1	2,009.0	191.1	91.3

3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	104,972.4	101,854.3	3,118.1	97.0
4	81816- Зөв монгол хүүхэд	3,151.0	3,151.0	-	100.0
5	81823- Боловсролын багшийн сургалт	1,947.3	1,947.3	-	100.0
6	81832- Нүүдлийн бүлэг	33,016.5	28,442.0	4,574.5	86.1
7	81834- Боловсролын стандарт сургалт	980,077.4	837,061.1	143,016.3	85.3
8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	43,436.5	43,436.5	-	100.0
9	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	54,564.0	54,306.1	257.9	100.0
10	83602-3Д нөөц хөрөнгөөс хуваарилсан	1,930.0	930.0	1,000.0	48.2
11	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	35.0	35.0	-	100.0
<b>Нийт</b>		<b>1,226,616.20</b>	<b>1,074,458.30</b>	<b>152,157.90</b>	<b>87.60</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

*/ мянган төгрөгөөр /*

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	76,129.9	60,324.7	НТШ
<b>Нийт дүн</b>		<b>76,129.9</b>	<b>60,324.7</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Ноён Уул” ХХК-тай гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 733,770.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,337.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсвийн хэтрэлт хэмнэлт-2 удаа
- Байгууллагын батлагдсан төсөв-1 удаа

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

##### **Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх 1 албан шаардлага, үндсэн хөрөнгө, зардлын данстай холбоотой 2 зөвлөмж өгсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,231.4	1	5,231.4	100.0
Зөвлөмж	2		2		100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>5,231.4</b>	<b>3</b>	<b>5,231.4</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,168.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

- Бараа материалын тайланд хандив тусламжаар ирсэн 14,168.0 мянган төгрөгийн материалыг дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **2,583.3** мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Тооцооллын алдаанаас шалтгаалж 2 багшийн ажилласан хоногийг буруу тооцож 173.8 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Илүү ажилласан цагийн бүртгэлгүйгээр багш Ш.Номин, П.Ганчимэг, жижүүр Б.Бямбажав 1,005.6 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20

дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/18 дугаар захирамжаар эрхлэгч 3.Сэлэнгэд ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,403.9 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.11 дэх “Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тайланд орлого илүү тусгасан	1	14,168.0			1	14,168.0	1	14,168.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>14,168.0</b>			<b>1</b>	<b>14,168.0</b>	<b>1</b>	<b>14,168.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон.	3	2,583.3	3	2,583.3								
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,583.3</b>	<b>3</b>	<b>2,583.3</b>								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээ хоцроосон	1						1	
<b>Нийт</b>	<b>1</b>						<b>1</b>	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.